



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2021



ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН -2021

Энэхүү тайлан нь Монголбанкны мэргэжилтнүүдийн бүтээл бөгөөд бусад гадны байгууллагуудын тоон мэдээлэл, судалгаа, шинжилгээний үр дүнг авч ашигласан. Тайланд тусгасан үр дүн, тайлбар, дүгнэлт зэрэг нь Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй. Монголбанк энэ тайланд дурдагдсан бусад байгууллагуудаас гаргасан мэдээ мэдээллийн үнэн бодит эсэхэд баталгаа өгөхгүй.

Монголбанк нь өөрийн ажлыг түгээн дэлгэрүүлэхийг дэмждэг бөгөөд хэсэгчлэн хэвлэн тараах зөвшөөрлийг шуурхай олгоно.

© МОНГОЛБАНК, 2022

АГУУЛГА

I. ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ	8
II. ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	10
2.1 Ажлын байрыг дэмжих зээл	12
2.2 Монголбанкны урт хугацаат репо санхүүжилт	15
2.3 Хөдөө аж ахуйн зээл	17
2.4 Ипотекийн зээл	19
III. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ ЭХЛЭХЭЭС ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	АБДЗ, репо, хөдөө аж ахуйн зээлийн цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон зээл, салбараар, 2021 он	11
Зураг 2.	АБДЗ, Репо төлөвлөгөөний хүрээнд хадгалагдсан ажлын байр, салбараар	11
Зураг 3.	ААН, иргэдэд олгосон зээлийн мэдээлэл	12
Зураг 4.	АБДЗ олголт, салбараар (тэрбум ₮, эзлэх хувь)	12
Зураг 5.	Хадгалсан ажлын байрны тоо, зээлчдэгчээр	13
Зураг 6.	Олгосон зээлийн тоо, зээлчдэгчээр	13
Зураг 7.	ААН, иргэдэд олгосон зээлийн мэдээлэл	16
Зураг 8.	Репо санхүүжилт, салбараар, эзлэх хувь	16
Зураг 9.	Хадгалсан ажлын байрны тоо, зээлдэгчээр	17
Зураг 10.	Олгосон зээлийн тоо, зээлчдэгчээр	17
Зураг 11.	Зээл олголт хуулийн этгээдийн хэлбэрээр, тэрбум ₮	18
Зураг 12.	Дундаж санхүүжилтийн хэмжээ, сая ₮	18
Зураг 13.	Тухайн жилд олгосон зээл болон дахин санхүүжилтийн нийлбэр дүн	19
Зураг 14.	Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь, насны ангиллаар	20
Зураг 15.	Нийт зээлдэгчийн тоонд эзлэх хувь, насны ангиллаар	20
Зураг 16.	Ипотекийн зээл олголт, иргэдийн цалингийн ангиллаар	21
Зураг 17.	Ковид-19 цар тахлын гол үйл явдал, арга хэмжээний тойм (2019.12-2021.03)	22
Зураг 18.	Ковид-19 цар тахлын нийт эдийн засагт нөлөөлөх сувгууд	23
Зураг 19.	Шинээр олгосон зээлийн жилийн өөрчлөлт	24
Зураг 20.	Эргэн төлөлтийн жилийн өөрчлөлт, салбараар	25
Зураг 21.	Нийт зээлийн үлдэгдэл	26
Зураг 22.	Уул уурхайн бус салбарын зээлийн үлдэгдэл	26
Зураг 23.	ЖДҮ-ийн зээлийн үлдэгдэл	27
Зураг 24.	Нийт зээлийн үлдэгдэл, салбараар	28

Зураг 25.	Мөнгөний нийлүүлэлт	29
Зураг 26.	Хүүний түвшин	29
Зураг 27.	Ажиллагсдын тооны жилийн өсөлт 2020 он, салбараар	30
Зураг 28.	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин	30
Зураг 29.	Хадгалсан ажлын байрны тоо, мянгаар	31
Зураг 30.	ААН-ийн борлуулалтын орлогын өсөлт, 2020 он	32
Зураг 31.	ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэл	33
Зураг 32.	ДНБ-ий өсөлт, эцсийн ашиглалт	33
Зураг 33.	ДНБ-ий өсөлт	34
Зураг 34.	Улсын төсвийн тэнцлийн дүн болон орлого, зарлагын жилийн өсөлт	35
Зураг 35.	Төсвийн орлого, зарлага, нэр төрлийн ангиллаар	36
Зураг 36.	Импорт, бүрэлдэхүүн хэсгээр	38
Зураг 37.	Үргал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	38

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Цогц төлөвлөгөөний үнэлгээ	7
Хүснэгт 2.	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр	9
Хүснэгт 3.	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, 2021 он	10
Хүснэгт 4.	Зээл олголт тэрбум ₮, 2021 он	15
Хүснэгт 5.	Зээл олголт сая ₮, зориулалтаар	18
Хүснэгт 6.	Зээл олголт 2021.03-2021.12 сар, тэрбум ₮	20
Хүснэгт 7.	ААН-үүдэд үүсэж буй голлох хүндрэл бэрхшээлүүд, давхардсан тоогоор	32

ХУРААНГУЙ

Ковид-19 вирус дэлхий нийтээр хурдацтай тархаж, цар тахлын түвшинд хүрч улс орнуудын эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг авчирч, нийлуулэлт төдийгүй эрэлтэд нэгэн зэрэг сэргөөр нөлөөлж эхэлсэн. Цар тахлаас үүсэж буй энэхүү өөрчлөлт нь 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас илүү сөрөг хор уршигтайг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Цар тахлын энэхүү хямрал нь өрхийн амьжиргаа, бизнесийн байгууллагын санхүүгийн байдалд шууд сэргөөр нөлөөлж улмаар санхүүгийн тогтвортой байдалд өндөр эрсдэл учруулж байгаа нь бодлого боловсруулагчдын өмнө шинэ, томоохон сорилтыг бий болгосон.

Монгол Улсын хувьд 2020 оны 3 дугаар сард анхны хөл хорио тогтоосноор Ковид-19 вирусын дотоод эдийн засагт үзүүлэх нөлөө эхэлсэн гэж хэлж болно. Халдвартын тохиолдол, тархалтын хурд зэргээс шалтгаалан хөл хориог дотооддоо тогтоосноор нийт эрэлт огцом буурч өрх, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан бол нөгөө талаас дэлхий нийтийг хамарсан тархалтаас үүдэн тээвэрлэлтийн доголдол үүсэж, хил боомт дээр бараа бүтээгдэхүүний нийлуулэлт хумигдаж, эдийн засгийн бүхий л салбаруудад сэргөөр нөлөөлж байна. Цар тахлын үр дагавар нь өрх болон аж ахуйн нэгжүүдэд хүндээр туссан бөгөөд өрхийн түвшинд ажилгүй болох, орлогын эх үүсвэр тасалдах, өр зээлийн төлбөрөө хугацаандаа төлөх

боломжгүй болох, аж ахуйн нэгжийн хувьд нийт эрэлт буурсан, нийлүүлэлтийн доголдол үүссэн, зардлаа санхүүжүүлэх боломжгүй болсон зэрэг хүндрэлүүд үүссэн.

Олон улсын туршлагад суурилан Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон Монголбанкнаас эдгээр хүндрэлүүдийг даамжрахаас сэргийлэх зорилгоор сангийн болон мөнгөний бодлогын арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсэн. Эдгээр бодлого, арга хэмжээний хүрээнд Засгийн газраас 2021 оны 2-р сарын 17-ны өдөр "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г боловсруулж баталсан.

Энэ тайлангаартус цогц төлөвлөгөөний хэрэгжилт болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд үзүүлсэн нөлөөг танилцуулж байна. Голлох үр дүнгүүдээс дурдвал 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон санхүүжилт нь эдийн засаг зогсонги байдалд орж, ажил эрхлэлт буурсан үед мөнгө, зээлийн өсөлтийг сэргээж, зээлийн хүүг бууруулж, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжиж, бизнесийн идэвхжлээр дамжин төсвийн орлого бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлжээ. Улмаар эдийн засаг 2021 онд сэргэж 1.4 хувийн өсөлттэй (уул уурхайн салбарын өсөлт 1.7%, уул уурхайн бус салбарын өсөлт 1.4%) гарлаа (Хүснэгт 1). Гэхдээ эдийн засгийн дотоод идэвхжлийг дэмжих зорилготой санхүүжилттэй

урсгал тэнцлийн алдагдал өссөн нь давхацсан байна. Энэ нь гадаад сөрөг шокуудтай орчинд эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангахад сорилт болж байна.

Тайлан нь дараах бүтэцтэй. Нэгдүгээр хэсэгт Засгийн газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний тухай танилцуулах бол хоёрдугаар хэсэгт цогц төлөвлөгөөний хүрээнд

олгохоор төлөвлөсөн зээл, санхүүжилтийн арга хэмжээ болон түүний хэрэгжилтийг тоймлон үзүүллээ. Гуравдугаар хэсэгт цар тахлаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн хориг арга хэмжээнүүдийн үр дүнд макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтүүд болон 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээр тус үзүүлэлтүүдэд гарсан нөлөөг харуулав.

Хүснэгт 1. Цогц төлөвлөгөө хэрэгжилтийн өмнөх ба дараах нөхцөл байдал

Их наяд ₮	Цогц төлөвлөгөө хэрэгжээгүй бол	Цогц төлөвлөгөө хэрэгжсэнээр
1. Мөнгөний нийлүүлэлт жилийн өөрчлөлт	23.8 -2.9%	27.9 13.8%
2. Зээлийн үлдэгдэл жилийн өөрчлөлт	16.6 -2.1%	20.7 21.3%
ҮҮ-н бус салбарын жилийн өөрчлөлт	14.7 -3.5%	18.8 23.2%
ЖДҮ жилийн өөрчлөлт	3.4 -4.0%	5.6 56.7%
3. Хүүний түвшин* жилийн зөрүү	14.3% -0.5%	13.2% -1.2%
4. Импорт, сая \$ жилийн өөрчлөлт	6,278 18.6%	6,849 29.4%
5. Ажиллагсдын тоо	851-959 мянга 2020 он	1,127 мянга 2021 он
6. Бодит ДНБ жилийн өөрчлөлт	26.7 -4.6%	27.0 1.4%
Уул уурхайн салбарын ДНБ жилийн өөрчлөлт	3.67 -9.9%	3.73 1.7%
Уул уурхайн бус салбарын ДНБ жилийн өөрчлөлт	23.0 -3.7%	23.3 1.4%
7. Улсын төсвийн тэнцэл	-4.5	-2.9
8. Инфляц	2.3%	13.4%

*тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү
Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

1 ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, орон сууцжуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, малчдын орлого амьжиргааг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2021 оны хоёрдугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г хэрэгжүүлж эхэлсэн ([Legalinfo.mn](#), 2022). Тус тогтоолын 5-д тусгагдсан ажлын байрыг болон хөдөө аж ахуйг дэмжих зээлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд Монголбанк, Зээлийн батлан даалтын сан, Хадгаламж даатгалын корпораци, банкууд холбогдох гэрээг байгуулж хамтран ажиллахаар тусгасан.

Тус төлөвлөгөө үндсэн 2 зорилго дэвшүүлсний нэг нь цар тахлын үед эдийн засгаа сэргээх явдал

юм. Энэ зорилгын хүрээнд дараах зорилтууд тавьсан: банк, санхүүгийн байгууллагаас олгох зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, Зээлийн батлан даалтын тогтолцоог ашиглан банкуудын эрсдэлийг хуваалцах, Засгийн газраас батлагдсан төсвийн хүрээнд зээлдэгчийн төлөх хүүний тодорхой хувийг хариуцан төлөх замаар зээлдэгчийн санхүүгийн дарамтыг зөвлөхөөр тооцсон. Нөгөө талаас улсын төсөвт тусгагдан гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийг эрчимжүүлэх замаар эдийн засгийн идэвхжлийг бий болгооор төлөвлөгөөнд тусгасан. Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бүтээн байгуулалтын төсөл болон эдийн засгийн хувьд үр ашигтай бусад төслүүдийг Улсын төсөв, Засгийн газрын өрийн хязгаарт дарамт үзүүлэхгүйгээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

Төлөвлөгөөний үндсэн ажил /хэрэгжих хугацаа/	Төлөвлөгөө тэрбум ₮	Санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх арга зам
Ажлын байрыг дэмжих зээл /2021 он/	2,000.0	Банкны эх үүсвэрт тулгуурлан ААН-д олгосон зээлд б хувь, иргэнд 7 хувийн хүүний дэмжлэг олгоно. 2021 оны хүүний дэмжлэгийг батлагдсан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй төсвийн зохицуулалт хийж санхүүжүүлнэ. 2022 оноос гарах хүүний дэмжлэгийг жил бүрийн төсөвт тусгана.
Ипотекийн зээл /2021-2022 он/	2,000.0	Монголбанк болон банкнуудын холимог эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.
Репо санхүүжилтийн зээл /2021 он/	2,000.0	Монголбанкны репо санхүүжилтийн эх үүсвэр. Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.
Хөдөө аж ахуйн зээл /2021 он/	500.0	Банкны эх үүсвэрт тулгуурлан зээлийн хүүний 7.65 хүртэл хувьд дэмжлэг өгөх замаар хэрэгжүүлнэ. 2021 оны хүүний дэмжлэгийг батлагдсан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй төсвийн зохицуулалт хийж санхүүжүүлнэ. 2022 оноос гарах хүүний дэмжлэгийг жил бүрийн төсөвт тусгана.
Орон сууцны хорооллын дэд бүтэц /2021-2024 он/	1,000.0	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хийх бүтээн байгуулалтын ажлыг дотоодын үнэт цаасны зах зээлд бонд гаргах замаар санхүүжүүлж, бусад гадаадын зээл, тусламжийн төслийд болон залуусыг хөдөлмөрт бэлтгэх сургалтыг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлнэ. Санхүүгийн хувьд үр ашигтай арилжааны шинж чанартай төслийдийг төсөв, Засгийн газрын өрд дарамтгүй хэлбэрээр хэрэгжүүлэх зохион байгуулалтыг хийхээр төлөвлөсөн.
Залуусыг хөдөлмөрт бэлтгэх сургалт /2021-2024 он/	500.0	
Том төслийдийн санхүүжилт /2021-2024 он/	2,000.0	
Нийт	10,000.0	

Цогц төлөвлөгөөнд тусгасан нийт 56 арга хэмжээний 25 арга хэмжээг 2021 онд, 3 арга хэмжээг 2021-2022 онд, 17 арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн, 11 арга хэмжээг халдвар тархалтын шаталсан түвшин, нөхцөл байдлаас хамаарч тухай бүрд нь хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 оны төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай гарсан байна (Сангийн яам).

Энэхүү тайлангийн тус цогц төлөвлөгөөний дараагийн хэсгүүдэд Монголбанкнаас оролцож, хамтран ажилласан (1) ажлын байрыг дэмжих зээл (АБДЗ), (2) репо санхүүжилтийн зээл, (3) хөдөө аж ахуйн зээл, (4) ипотекийн зээлийн 2021 оны санхүүжилтийн хэрэгжилт, үр дүнг дэлгэрэнгүй авч үзлээ.

2 ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөөний хүрээнд 2021 онд нийт 5.5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүйтэй зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд Засгийн газраас 2021-2024 онд жилд дунджаар 70-80 тэрбум төгрөгийн хүүний дэмжлэгийг олгохоор тооцсон. Энэ нь хүйтэй зээл авсан аж ахуйн нэгж, иргэд, малчадад санхүүгийн дэмжлэг болж, бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангана гэж үзсэн. Ажлын байрыг дэмжих, репо санхүүжилт, ипотек, хөдөө аж ахуйн зээлийн хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 61,719 зээлдэгчид 4.24 их наяд төгрөгийн санхүүжилт олгов. Үүнд цогц төлөвлөгөө хэрэгжсэнээс хойш 2021 он дуустал:

- АБДЗ-ийн хүрээнд нийт 25,514 зээлдэгчид 1,965.6 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Ингэснээр улсын хэмжээнд нийт 109.7 мянган ажлын байрыг хадгалахад дэмжлэг болохуйц;
- Урт хугацаат репо санхүүжилтийн хүрээнд нийт 36,622 ажилтантай 3,375 зээлдэгчид 834.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон;
- Ипотекийн зээлийн хувьд нийт 12,223 зээлдэгчид 955.7 тэрбум төгрөгийн дүн бүхий санхүүжилтийг олгов;
- Хөдөө аж ахуйн зээлийн хүрээнд нийт 20,607 зээлдэгчид 494.3 тэрбум төгрөгийн зээлийг олгожээ.

Хүснэгт 3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, 2021 он

Зээл, санхүүжилтийн хөтөлбөр	Зээлийн дүн		Зээлдэгчийн тоо	Хадгалсан ажлын байр
	Төлөвлөгөө тэрбум ₮	Биелэлт тэрбум ₮		
Ажлын байрыг дэмжих зээл	2,000.0	1,965.6	25,514	109,763
Урт хугацаат репо санхүүжилтийн зээл	2,000.0	834.9	3,395	36,622
Орон сууцны ипотекийн зээл	1,000.0	955.7	12,223	
Хөдөө аж ахуйн зээл	500.0	494.3	20,607	
Нийт	5,500.0	4,241.4	61,719	146,385


Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам

Ажлын байрыг дэмжих зээл болон урт хугацааны репо санхүүжилтийн хүрээнд олгосон нийт санхүүжилтийн 43 хувийг нь бөөний болон жижиглэнгийн салбарт, 18 хувийг үйлчилгээний бусад салбарт олгожээ (Зураг 1).


Дэмжлэг үзүүлсэн нийт 146 мянган ажлын байрны 35 хувь буюу 50,708 ажлын байрыг бөөний болон

жижиглэн худалдааны салбарт, 19 хувь буюу 27,131 ажлын байрыг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 13 хувь буюу 19,289 ажлын байрыг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 7 хувийг барилгын салбарт, бусад эдийн засгийн салбарт 19 хувь буюу 27,598 ажлын байрыг дэмжиж зээл олгосон байна (Зураг 2).

Зураг 1. АБДЗ, репо, хөдөө аж ахуйн зээлийн цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон зээл, салбараар, 2021 он



Зураг 2. АБДЗ, Репо төлөвлөгөөний хүрээнд хадгалагдсан ажлын байр, салбараар




Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам

2.1 Ажлын байрыг дэмжих зээл

Цогц төлөвлөгөөний 2.1-д тусгагдсан "Ажлын байрыг дэмжих зээл" нь цар тахлын гамшигийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах болон эдийн засгийг идэвхжүүлэх зорилтын хүрээнд банкуудын зээлийн эрсдэлийг бууруулах,


иргэд болон аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрыг дэмжих зорилтоор 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн (Сангийн яам, 2021).

Зураг 3. ААН, иргэдэд олгосон зээлийн мэдээлэл





Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам

Зураг 4. АБДЗ олголт, салбараар (тэрбум ₮, эзлэх хувь)



- Бөөний болон жижиглэн худалдаа
- Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
- Өрхийн үйл ажиллагаа
- Барилга
- Боловсруулах үйлдвэр
- Хөдөө аж ахуй
- Бусад

Зураг 5. Хадгалсан ажлын байрны тоо, зээлчдэгчээр**Зураг 5.** Олгосон зээлийн тоо, зээлчдэгчээр

Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам


Ажлын байрыг дэмжих зээлийн гүйцэтгэлийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харвал банкуудад нийт 6.4 их наяд төгрөгийн 62.9 мянган зээлийн хүсэлт ирсэн буюу нийт олгох

зээлээс 3 дахин их хүсэлт иржээ. Үүнээс 25,439 зээлд 1,952.6 тэрбум төгрөгийг олгож, зээл олголт 98.3 хувьтай байна.

Шигтгээ 1. Ажлын байрыг дэмжих зээлд хамрагдсан байдал

Монголбанкнаас явуулсан Бизнесийн түүвэр судалгаа (2021)-ны үр дүнгээр Аж ахуйн нэгж (ААН)-үүдийн үйл ажиллагаанд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдээс (1) НДШ болон ААНОАТ-ын хөнгөлөлтүүд, (2) Ажлын байрыг дэмжих 3 хувийн зээл (3) Ус цахилгааны төлбөрийн хөнгөлөлт зэрэг нь ААН-үүдийн үйл ажиллагаанд хамгийн их дэмжлэг болсон гэж хариулсан.

Нийт ААН-үүдийн 1/4 нь ажлын байрыг дэмжих зээлд хамрагдаж чадсан бөгөөд нийт ААН-үүдийн дунджаар 17 хувьд нь бодит дэмжлэг болсон гэж хариулжээ. Монголбанк болон MYXAYT-аас хийсэн түүвэр судалгааны үр дүнгүүд өөр хоорондоо ижил төстэйгээс гадна Ажлын байрыг дэмжих зээлийн бодит статистик үзүүлэлттэй нийцтэй байна. Тухайлбал, түүвэр судалгаагаар Ажлын байрыг дэмжих зээлийн дийлэнх буюу 49 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, 8 хувь нь барилгын салбарт, 10 хувь нь боловсруулах салбарт тус тус олгогдсон үр дүнтэй байна.



Нийт дүнгийн ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд 5,714 аж ахуйн нэгжид 1,305.4 тэрбум төгрөгийн зээл олгосон нь 81,612 ажлын байрыг, 19,800 иргэнд 660.2 тэрбум төгрөгийн зээл олгосон нь 28,151 ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлжээ (Зураг 3, Зураг 5).

Ажлын байрыг дэмжих зээлийн дийлэнх буюу 47 хувийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт, 20 хувийг үйлчилгээний бусад үйл

ажиллагааны салбарт олгосон байна. Харин олгосон зээлийн 23 хувь буюу нийт 458 тэрбум төгрөгийн зээлийг хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, боловсруулах үйлдвэрийн болон барилгын салбарт олгосон бол бусад эдийн засгийн 17 салбарт 9 хувийг олгожээ. Энэхүү зээлийн зориулалт нь эргэлтийн хөрөнгийн зориулалттай учир бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар, үйлчилгээний бусад үйл ажиллагаанд дэмжлэг болжээ.

■ 2.2 Монголбанкны урт хугацаат репо санхүүжилт

Монголбанкнаас дэлхийн бусад улс, орнуудын төв банкуудын Ковид-19-ын цар тахлын үед хэрэгжүүлж буй сайн туршлагыг судалж, зээлийг багцлан үнэт цаасжуулан репо нөхцөлөөр санхүүжилт олгох механизмыг 2020 оны 4 дүгээр улиралд нэвтрүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд

Монголбанкнаас 2 жил хүртэл хугацаатайгаар банкуудад репо нөхцөлөөр санхүүжилт олгож, банкууд эцсийн зээлдэгчид 10.5 хувийн хүйтэйгээр шинээр зээл олгох, олгосон зээлийг дахин санхүүжүүлэх арга хэмжээ авсан.

Хүснэгт 4. Зээл олголт тэрбум ₮, 2021 он

Зээлийн дүн	Зээлдэгч	Үүнээс:								Зээлдэгчийн ажлын байр	
		ААН		Иргэн		Улаанбаатар		Орон нутаг		УБ хот	Орон нутаг
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо		
834.9	3,395	648.8	1,814	186.1	1,581	690.1	2,110	144.8	1,285	32,609	3,780

Эх сурвалж: Монголбанк

2021 онд нийт 4,126 зээлдэгчийн 1,089 тэрбум төгрөгийн хүсэлт ирүүлснээс 834.9 тэрбум төгрөгийг 3,395 (1,814 аж ахуйн нэгж, 1,581 иргэн) зээлдэгчид олгоод байна. Ингэснээр улсын хэмжээнд нийт 36.6 мянган ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлжээ. Нэг иргэний зээлийн дундаж хэмжээ 117.1 сая төгрөг, аж ахуйн нэгжийн авсан дундаж зээлийн хэмжээ 355.3 сая төгрөг байна. Урт хугацаат репо арилжааны нэмэлт нөхцөлд¹ санхүүжилтийн 70 хувийг шинэ зээлд, 30 хувийг (зээлдэгчийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор) дахин санхүүжилтэд

олгохоор тусгасан бөгөөд тайлант хугацаанд нийт зээлийн 41 хувь нь шинээр олгосон зээлд, 59 хувь нь өмнө нь олгосон зээлийн дахин санхүүжилтэд зарцуулагджээ (Зураг 7).


Монголбанкны урт хугацаат репо санхүүжилт нь хүртээмжтэй өсөлтийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдол бүхий жижиг дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарын өрийн дарамтыг бууруулах зорилгын хүрээнд эх үүсвэрийг анх уг салбарын аж ахуй нэгж, иргэнд олгож өхэлсэн. Үүний дараа цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг богино хугацаанд арилгах, ажлын байрыг хадгалах зорилгоор үйлчилгээ, боловсруулах, бөөний ба

¹ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 2-р сарын 4-ний А-47, 2021 оны 2-р сарын 19-ний А-58, 2021 оны 3-р сарын 26-ны А-89, 2021 оны 7-р сарын 6-ны А-185, 2021 оны 9-р сарын 22-ны А-247 тушаалууд

жижиглэн худалдааны салбаруудаар хамрах хүрээг өргөтгөсөн юм. Улмаар, зээл олголтын задаргааг салбараар нь авч үзвэл ажлын байрыг дэмжих зээлийн адил репо санхүүжилтийн хүрээнд бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарыг (33 хувь) голлон дэмжсэн байна. Мөн олгосон зээлийн 19 хувийг боловсруулах


үйлдвэрлэл, 11 хувийг үйлчилгээний бусад салбар, 6 хувийг барилга (46 тэрбум төгрөг), эрүүл мэнд болон нийгмийн үйлчилгээ (51 тэрбум төгрөг), зочид буудал байр орон сууцны нийтийн хоолны үйлчилгээний салбарт тус тус олгожээ. Үлдсэн бусад эдийн засгийн 13 салбарт 16 хувийг олгосон байна (Зураг 8).

Зураг 7. ААН, иргэдэд олгосон зээлийн мэдээлэл




Зураг 8. Репо санхүүжилт, салбараар, эзлэх хувь



Зураг 9. Хадгалсан ажлын байрны тоо, зээлдэгчээр

Эх сурвалж: Монголбанк

Зураг 10. Олгосон зээлийн тоо, зээлчдэгчээр

■ 2.3 Хөдөө аж ахуйн зээл

Цогц төлөвлөгөөнд "Хөдөө аж ахуйг дэмжих" 500 тэрбум төгрөгийн зээлийн хөтөлбөр багтсан. Уг хөтөлбөр нь хаврын тариалалтад 100 тэрбум төгрөг, ноос, ноолуур бэлтгэлд 200 тэрбум төгрөг, малчдыг дэмжих зориулалтаар 200 тэрбум төгрөгийн зээл гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Хөтөлбөрийн хүрээнд зээлийн санхүүжилтийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан жилийн 3 хувийн хүйтэй олгосон.

Хөдөө аж ахуйн зээлийн гүйцэтгэлийг 2021 оны эцсийн байдлаар харвал банкуудад нийт 20,607 зээлдэгчид 494.3 тэрбум төгрөг олгож, хэрэгжилт

99 хувтай байна (Хүснэгт 5). Хөдөө аж ахуйн зээл олголтыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал малчдыг дэмжихэд 40 хувь (199.6 тэрбум төгрөг), арьс шир бэлтгэлд 17 хувь (86 тэрбум төгрөг), ноолуур ноос бэлтгэлд болон махны нөөц бүрдүүлэхэд 20 хувь (98 тэрбум төгрөг)-ийн зээлийг тус тус олгосон байна. Харин зээлдэгчийн тоогоор авч үзвэл хөдөө аж ахуйн зээлийн дийлэнх буюу 19,870 зээлдэгчид (96 хувь) нь малчдын орлого, амжиргааг дэмжих зээлд хамрагдсан байна.

Хүснэгт 5. Зээл олголт сая ₮, зориулалтаар


Зээлийн төрөл	Зээлийн хэмжээ	Хувь	Зээлдэгчийн тоо
Малчдыг дэмжих зээл	199,643	40%	19,870
Махны нөөц бүрдүүлэх зээл	97,597	20%	46
Ноолуур бэлтгэлийн зээл	94,921	19%	38
Хаврын тариалалтын зээл	43,301	9%	629
Улаан буудай, тосны ургамал худалдан авах	42,415	9%	11
Арьс шир бэлтгэлийн зээл	13,202	3%	9
Ноос бэлтгэлийн зээл	3,215	1%	4
Хөдөө аж ахуйн зээл нийт	494,294	100%	20,607

Эх сурвалж: Монголбанк

Энэхүү хөнгөлөлттэй зээлийн 42 хувь иргэд, 58 хувь нь хуулийн этгээдэд олгогдсон бөгөөд иргээдэд олгосон зээлийн 96 хувь нь малчдыг дэмжих зээл хэлбэрээр олгогджээ. Харин хуулийн этгээдийн хувьд махны нөөц бүрдүүлэх, ноолуур бэлтгэх, улаан буудай, хаврын тариалалтын


зээлүүд голлох хэсгийг бүрдүүлж байна. Зээлийн ангилал бүрд дундаж санхүүжилтийн хэмжээг тооцоход хамгийн их санхүүжилт болох 3.9 тэрбум төгрөгийг улаан буудай, тосны ургамал худалдан авахад олгожээ.

Зураг 11. Зээл олголт хуулийн этгээдийн хэлбэрээр, тэрбум ₮



Эх сурвалж: Монголбанк

Зураг 12. Дундаж санхүүжилтийн хэмжээ, сая ₮



2.4 Ипотекийн зээл


Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ны нэг хэсэг нь агаар, орчны бохирдлыг бууруулах үндсэн зорилгын хүрээнд бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, тэдгээрийг орон сууцжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021-2023 онуудад нийт 2 их наяд төгрөгийн эх үүсвэрээр орон сууцны хөтөлбөрийг санхүүжүүлэх юм.

Хөтөлбөрийн хүрээнд зээл олголтын нөхцөлийг хөнгөвчилж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн орон сууцны ипотекийн

хөнгөлөлттэй зээлийн хүүг жилийн 6 хувь болгон бууруулсан (Монголбанк, 2021). Уг зээлийг Монголбанк 60 хувь, банкуудын 40 хувийн эх үүсвэртэйгээр хэрэгжүүлж байна.

Зээлт олголтыг харвал 2021 онд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр нийтдээ 1.6 их наяд орчим төгрөг (өмнөх оноос 75.1 хувиар өссөн) буюу анх хэрэгжүүлж эхэлсэн 2013 оноос хойших хамгийн их санхүүжилт олгожээ (Зураг 13). Орон сууцны ипотекийн санхүүжилтэд 2021 онд сард дунджаар 129.5 тэрбум төгрөг олгосон буюу зээл олголт өмнөх оноос сард дунджаар 55.5 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 13. Тухайн жилд олгосон зээл болон дахин санхүүжилтийн нийлбэр дүн



Эх сурвалж: Монголбанк

Цогц төлөвлөгөөний хүрээнд 2021 оны 3 дугаар сараас 12 дугаар хооронд Монголбанкнаас нийт 2,231.7 тэрбум төгрөгийн 27,195 зээлийн хүсэлт ирүүлснээс 955.7 тэрбум төгрөгийг 12,223 зээлдэгчид олгожээ (Хүснэгт 6). Энэ нь тус оны

нийт санхүүжилтийн 61.5 хувьтай тэнцэж байна. Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 76.1 сая төгрөг, үүнээс Улаанбаатар хотод олгосон зээлийн дундаж 82.9 сая төгрөг, орон нутагт 55.7 сая төгрөг байна.

Хүснэгт 6. Зээл олголт 2021.03-2021.12 сар, тэрбум ₮

Зээлийн дун	Зээлдэгч*	Үүнээс:					
		Улаанбаатар		Орон нутаг		Шинэ зээл	Дахин санхүүжилт
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
955.7	12,223	794.1	9,382	161.6	2,841	921.2	34.5


*Дахин санхүүжилт авсан зээлдэгчдийн тоог оруулаагүй

Эх сурвалж: Монголбанк

Цогц төлөвлөгөөний хүрээнд олгож буй ипотекийн зээл нь бага, дунд орлоготой залуучууд руу илүүтэй чиглэж байгаа нь орон сууцны зээл зорилтот бүлэгтээ хүрч буйг илтгэж байна (Зураг 15, Зураг 16). Тухайлбал, 2021 оны 12 дугаар сарыг 2 дугаар сартай харьцуулахад 35-с доош


насны иргэдийн нийт зээлийн үлдэгдэл болон зээлдэгчийн тоонд эзлэх хувь өссөн бол 35-с дээш насны иргэдийн хувь буурсан байна. Нөгөө талаас, ипотекийн зээлийн талаас илүү хувийг 2.5 саяас доош орлоготой иргэд авчээ.


Зураг 14. Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь, насны ангиллаар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 15. Нийт зээлдэгчийн тоонд эзлэх хувь, насны ангиллаар



Зураг 16. Ипотекийн зээл олголт, иргэдийн цалингийн ангиллаар

Эх сурвалж: Монголбанк


Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын тохиолдлууд дотоодод илэрч, хөл хорооны хатуу дэглэмийг хэрэгжүүлж эхэлснээр иргэдийн орлого буурч, банкны зээлийн эргэн төлөлт тасалдах эрсдэл үүссэн тул эдийн засгийн хүндрэлийн үед өрхийн орлогыг дэмжих, худалдан авах чадварыг хамгаалахад бодитой дэмжлэг үзүүлэхээр хөтөлбөрийн зээлийн төлбөрийг хүү хуримтлуулж

тооцоогүй нөхцөлөөр иргэдийн хүсэлтийг үндэслэн шат дараатай таван удаа хойшшуулсан. Уг арга хэмжээний үр дүнд давхардсан тоогоор нийт 276 орчим мянган зээлдэгч хамрагдаж 3.5 орчим их наяд төгрөгийн үлдэгдэлтэй зээл 1 их наяд төгрөгийн төлбөрөөс дунджаар 2.5 жилийн хугацаанд чөлөөлөгдсөн.

3 ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ ЭХЛЭХЭЭС ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮЕИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхий нийтэд Ковид-19 вирус дэгдэж эхэлсэн цагаас Монгол Улс уг вирусын тархалтаас урьдчилан сэргийлэх, тархалтыг хумих чиглэлд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, сургууль, цэцэрлэгийг хаах, хөл хорио тогтоох, хилийн хяналт тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг шуурхай авч хэрэгжүүлсэн (Зураг 17).


Зураг 17. Ковид-19 цар тахлын гол үйл явдал, арга хэмжээний тойм (2019.12-2021.03)



Эдгээр арга хэмжээ нь эрүүл мэндийн хохирлыг бууруулж, хүний амь эрсдэхээс тодорхой түвшинд урьдчилан сэргийлж чадсан хэдий ч нөгөө талдаа өрх бүл, ААН, санхүүгийн байгууллагуудад хүндээр туссан. Ялангуяа, эдийн засгийн нийт эрэлт огцом буурах, өрх, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа алдагдсан

бол нөгөө талдаа дэлхий нийтийг хамарсан тархалтаас үүдэн тээвэр, логистик, хил боомт дээр догогдол үүсэх, ингэснээр нийлүүлэлтийн сөрөг нөлөөллүүд эдийн засагт сөргөөр нөлөөлсөн. Цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөг хялбарчлан Зураг 18-д харуулав.

Зураг 18. Ковид-19 цар тахлын нийт эдийн засагт нөлөөлөх сувгууд



Цар тахлаас шалтгаалан ААН-үүдэд бараа үйлчилгээний эрэлт бууран, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орсон бөгөөд дийлэнх салбарын ААН-үүдийн борлуулалтын орлого ихээр агшаад байв. ААН-үүдийн дунд явуулсан түүвэр судалгаагаар цар тахлын тархалт түүнээс сэргийлэх, хөл хороог хязгаарлах арга хэмжээний улмаас дийлэнх ААН-үүдэд үйл ажиллагааны чиглэлээс үл хамааран бараа үйлчилгээний эрэлт буурах, эргэлтийн хөрөнгийн хомсдол бий болох, нийлүүлэлт

тасалдах зэрэг хүндрэлүүд голлон үүссэн. Улмаар цар тахлаас өмнө дунджаар 20 хувийн тогтвортой өсөлттэй байсан хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад салбарын ААН-үүдийн борлуулалтын орлого 37 хүртэлх хувиар буурсан. ААН-үүдийн борлуулалтын орлогын өсөлтийг харвал эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйгаас бусад бүх салбаруудын борлуулалтын орлого агшаад байв.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зээл олголт зогсонги байдалд орж, зээлийн тасалдал үүсэх эрсдэлтэй байв. Цар тахлын улмаас эдийн засаг, бизнесийн идэвхжил суларсны зэрэгцээ банкуудын зээл олгох сонирхол багассаны улмаас зээл олголт 2019 оноос хойш зогсонги байдалтай, 2020 оны эцсийн байдлаар шинээр олгосон зээлийн жилийн өсөлт -4 хувьтай гарсан (Зураг 19). Эдийн засгийн салбаруудаар авч үзвэл, бөөний ба жижиглэн худалдаа, санхүү даатгал,

боловсруулах, барилгын салбаруудад 2020 онд зээл агшсан дүр зурагтай байв. Түүнчлэн, Монгол Улсын хэмжээнд 2021 оны 1 дүгээр сарын байдлаар Ковид-19 цар тахлын улмаас нийт зээлийн дүнгийн 50.8 хувь нь төлөгдөхгүй эрсдэл үүссэн бөгөөд цаашид бодлогын арга хэмжээ аваагүй бол томоохон зээлийн эрсдэл үүсгэхээр байв (Монголбанк, 2022).

Зураг 19. Шинээр олгосон зээлийн жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийг сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний үр дүнд зээл тасалдах эрсдэлээс сэргийлж, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэв. Бүх нийтийн вакцинжуулалтын дараагаас хөл хорио суларч, эдийн засгийн идэвхжил сэргэж эхлэх үед цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн нь эдийн засагт шинээр олгох зээлийн хэмжээг огцом өсгөж, 2021 оны эцэс гэхэд шинээр олгосон зээлийн жилийн өсөлт 53 хувьд хүрчээ.

Нийт олгосон зээлийн өсөлтийг дотор нь секторын бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан харвал,

хувийн байгууллага болон иргэдэд олгосон зээл гол хэсгийг бүрдүүлж байна. Засгийн газрын хэрэгжүүлсэн 10 их наядын цогц төлөвлөгөөний нэг зорилт нь импортыг орлох бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих, санхүүгийн эх үүсвэрийг шийдэх байсан бөгөөд уул уурхайгаас хамааралтай манай улсын хувьд уул уурхайн бус салбарт зээл олгох нь чухал байв. Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс өмнө уул уурхайн бус салбарт олгосон зээл 8 хувийн бууралттай байсан бол 2021 оны 12 дугаар сарын байдлаар жилийн 54 хувиар өсөлттэй байна (Зураг 19).

Зураг 20. Эргэн төлөлтийн жилийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Цар тахлын үеэр төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн нэг нь зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан. Үүнээс шалтгаалан банкны салбар дахь зээлийн эргэн төлөлтийн хэмжээ буурч, 2021 оны эхний улирал хүртэл жилийн дундаж өсөлт 1.8 хувьтай байв. Харин цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээс хойш зээлийн эргэн төлөлт нэмэгдэж, ялангуяа худалдаа, барилга, боловсруулах салбарын үзүүлэлтүүд сайжарсны дунд дундаж өсөлт 26.3 хувьд хүрч, зээлийн эргэн төлөлт хэвийн түвшинд очжээ (Зураг 20).

Шинээр зээл олголт нэмэгдсэнтэй холбоотойгоор зээлийн үлдэгдэл, мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэв. Нийт зээлийн үлдэгдэл 2021 оны эцсийн байдлаар 20.7 их наяд төгрөгт хүрч, үүний 90 гаруй хувийг уул уурхайн бус салбарын зээл бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс харгалzan 21.3, 23.2

Зураг 21. Нийт зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

хувиар тус тус өссөн байна (Зураг 21). Хэрэв цогц төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй бол нийт зээлийн үлдэгдэл 2.7 хувиар буурч, одоогийн зээлийн үлдэгдлийн 80 хувьтай тэнцэх байв (Зураг 21). Уул уурхайн бус салбарын зээлийн үлдэгдлийн хувьд төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй тохиолдолд жилийн өсөлт -3 хувьтай болж, одоогийн үлдэгдлийн 78 хувьтай байх эрсдэлтэй байжээ (Зураг 22). Энэ хэмжээгээр эдийн засгийн идэвхжил суларч, өсөлт, ажил эрхлэлтэд том цохилт болох эрсдэлтэй байв. Түүнчлэн, АБДЗ, репо санхүүжилттэй зээлийг Жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдэд тулхүү олгосныг Зураг 23-с харж болно. Тухайлбал, ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдэл 5.6 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь цогц төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй үетэй харьцуулахад даруй 40 орчим хувиар илүү байгаа юм.

Зураг 22. Уул уурхайн бус салбарын зээлийн үлдэгдэл




Зураг 23. ЖДҮ-ийн зээлийн үлдэгдэл

Эх сурвалж: Монголбанк

Цар тахлын үед эдийн засгаа сэргээх үүднээс 2021 онд 4.2 их наяд орчим төгрөгийн санхүүжилтийг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд олгожээ. Санхүүжилтийг голлох салбаруудаар салган

авч үзвэл жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчдэд нийт дүнгийн 29 хувийг олгосон бол уул уурхайн салбарт хамгийн бага зээл олгосон байна (Зураг 24).


Зураг 24. Нийт зээлийн үлдэгдэл, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Харин мөнгөний нийлүүлэлт цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Хэрэв тус төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй тохиолдолд 2021 оны эцэс гэхэд нийт мөнгөний нийлүүлэлт бодит утгаас 4.1 их наяд төгрөг буюу 15 хувиар бага байх байжээ (Зураг 25).

Нөгөөтэйгүүр, зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд хүүний түвшин буурах хандлагатай болсон бөгөөд 10 их наядын цогц төлөвлөгөөний нөлөө орж ирснээр зээлийн дундаж хү 2021 оны 5 дугаар сард түүхэн доод түвшин болох жилийн 11.5 хувьд хүрчээ.

Зураг 25. Мөнгөний нийлүүлэлт**Зураг 26.** Хүүний түвшин

Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ 2. Өрхийн амьжиргааны түвшин, зээлийн эргэн төлөх чадварт үзүүлэх нөлөөлөл

Ц.Бямбацогт, С.Билгүүнзуул, Б.Ананд (2021) нарын Засгийн газар болон Монголбанкнаас цар тахалтай холбоотойгоор 2020 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний өрхийн амьжиргааны түвшин, банк санхүүгийн байгууллагаас авсан зээлээ төлөх чадварт үзүүлэх нөлөөллийг өрхийн түвшний микро тоон өгөгдөл ашиглан стресс тестийн шинжилгээ хийхдэд дараах голлох үр дүнгүүд гарсан. Үүнд:

НДШ, ХХОАТ-ын хөнгөлөлт нь иргэдийн зээлийн чанаргүй болох магадлалыг 1.4 хувиар, амьжиргааны доод түвшнээс бага хэрэглээтэй өрхийн хувийн жинг 2.8 хувиар нэмэгдүүлэх;

Зээлийн төлбөр хугацааг сунгасан арга хэмжээний хувьд өрхийн зээл чанаргүй болох магадлал болон хэрэглээний наад захын хэрэгцээг хангахгүй нөхцөлд хүрэх магадлалыг тус тус 1.3 хувиар нэмэгдүүлэх буюу өрхөд чиглэсэн арга хэмжээнүүд бүгд хэрэв хэрэгжээгүй тохиолдолд иргэдийн зээл чанаргүй болох магадлал 10.2 хувь, ядуурлын түвшин 8.0 хувиар нэмэгдэх эрсдэлтэй байжээ.

Арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дунд цар тахлын өрхөд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байсан хэдий ч арга хэмжээг хэрэгжүүлэхдээ өрхийн хэрэгцээ, шаардлагыг тусгалгүй, бүх иргэд, өрхөд тэгш байх зарчим баримталсан нь зарим талаар бодлогын зардал өндөр байхад нөлөөлжээ.

Цар тахлын улмаас хөдөлмөрийн зах зээл дээр ажил эрхлэлт огцом буураад байв. Ажиллагсдын тоо 2020 онд 1124.5 мянга болж 2019 оноос 63.9 мянгаар, 2018 оноос 131.8 мянгаар тус тус буураад байв. Нийт эдийн засгийн салбаруудын 50 орчим хувьд нь ажиллагсдын тоо буурсан,

Зураг 27. Ажиллагсдын тооны жилийн өсөлт 2020 он, салбараар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цар тахлын тархалтыг хумих зорилгоор Засгийн газраас 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 2 дугаар сарын хооронд тогтоосон хөл хорионууд нь хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийг улам муутгаж, 2021 оны 1 дүгээр улиралд нийт ажил эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 11 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 5 нэгж хувиар унаад байв

эсвэл зогсонги байдалд орсон бөгөөд ялангуяа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом, наадам, өрхийн үйл ажиллагаа зэрэг үйлчилгээний салбарууд, мөн уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоо эрс буурав (Зураг 27).

Зураг 28. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин




(Зураг 28). Түүнчлэн, цар тахлын хямрал нь ААН-үүдийн санхүүгийн байдалд шууд сөргөөр нөлөөлснөөр зарим ААН-үүд үйл ажиллагаагаа хумин, зогсоосноор хөдөлмөрийн идэвхтэй хүн амын тоонд багтаж байсан иргэдийг идэвхгүй хүн амын тоо руу шилжихэд нөлөөлжээ.

Цогц төлөвлөгөөний үр дунд хөдөлмөр эрхлэлт огцом буурах эрсдэлээс сэргийлж, хөдөлмөрийн зах зээл цар тахлын өмнөх үе рүү дөхөн сэргэж байна. Цар тахлын үед тогтоосон хөл хориог аажмаар цуцалж, 10 их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 2021 оны турш хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал сайжирч, хөдөлмөр эхлэлтийн түвшин 2021 оны 4 дүгээр улиралд оны эхнээс 3.5 нэгж хувиар нэмэгдэн, ажилгүйдлийн түвшин 8 хувь болж буурав. Тус цогц төлөвлөгөөний хүрээнд 2021 онд олгосон санхүүжилт нь

146,385 ажлын байрыг хадгалсан тухай өмнөх зээл, санхүүжилтийн хэсэгт харуулсан. Харин Дэлхийн банк (2022) болон Сангийн яамнаас 10 их наядын цогц төлөвлөгөөний 2021 оны нийт ажил эрхлэлтэд үзүүлсэн нөлөөг тооцож, цогц төлөвлөгөөний хүрээнд нийт 168,000-276,000 ажлын байр хадгалагдсан гэж дүгнэжээ (Зураг 29). Өөрөөр хэлбэл, цогц төлөвлөгөө хэрэгжээгүй байсан бол нийт ажиллагсдын тоо 2021 онд 20 хувиар буурч, 900 мянга орчим болох эрсдэлтэй байсан гэж тооцож байна.

Зураг 29. Хадгалсан ажлын байрны тоо, мянгаар



Эх сурвалж: YCX, Сангийн Яам, Дэлхийн Банк¹

¹ Дэлхийн Банкны хоёр аргачлал аль аль нь улирлын засварлалт хийсэн бөгөөд хоёр дахь аргачлалд хөл хорионы түвшин болон хөдөлгөөнт байдлыг тооцоололдоо оруулсан болно.

Хүснэгт 7. ААН-үүдэд үүсэж буй голлох хүндрэл бэрхшээлүүд, давхардсан тоогоор

Гол хүндрэл, бэрхшээл	АХБ (2020.12)	ҮСХ (2021.03)	МҮХАҮТ (2021.09)
Бараа үйлчилгээний эрэлтийн бууралт	53%	51%	
Эргэлтийн хөрөнгийн хомсдол	44%	51%	
Нийлүүлтийн доголдол	72%	43%	
Тодорхойгүй байдал	57%	33%	
Санхүүгийн байдлын хүндрэл		55%	
Үйл ажиллагаагаа түр зогсох		47%	
Ажилчдын цалинг олгох хүндрэл	19%	32%	
Орлогын бууралт	77%		


Эх сурвалж: АХБ, ҮСХ, МҮХАҮТ-ын түүвэр судалгаануудын үр дүн

Зураг 30. ААН-ийн борлуулалтын орлогын өсөлт, 2020 он



Эх сурвалж: Монголбанк, Татварын Ерөнхий Газар


Цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээний улмаас эдийн засгийн идэвхжил сулраад байв. Монгол Улсын эдийн засаг 2020 онд сүүлийн 30 жилийн хамгийн огцом уналттай буюу 4.6 хувиар агшив (Зураг 31). Цар тахлын тархалтаас сэргийлэх бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы нөлөөгөөр бизнесийн орчинд тодорхой бус байдал нэмэгдэж, бизнесийн идэвхжил огцом сулран, хөдөлмөр эрхлэлт буурч, зарим үйлдвэрлэл, үйлчилгээ тодорхой хугацаанд тэг зогсолт хийхэд хүрсэн. Улмаар уул уурхай болон үйлчилгээний дийлэнх салбарууд огцом агшиж, аж үйлдвэрийн салбарын өсөлт саарсан нь ийнхүү эдийн засгийн идэвхжил сулрахад нөлөөлөв.

Зураг 31. ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэл

Эх сурвалж: УСХ

Цар тахлыг хязгаарлах арга хэмжээ, хилийн хязгаарлалт, гадаад эрэлт буурсан зэрэг нь экспорт агших, ГШХО хойшлох, улмаар дотоод эрэлт унахад нөлөөлсөн. Засгийн газар, Монголбанкнаас цар тахлын сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын багц арга хэмжээний¹ нөлөөгөөр өрхийн болон

¹ МУЗГ-аас "Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийн хүрээнд татварын хөнгөлөлт, НДШ-ийн чөлөөлөлт, орон сууцны төлбөрөөс чөлөөлөх, түлшний татаас, хүүхдийн мөнгөн халамж, вакцины урамшуулал, бусад халамж, тэтгэмжийн арга хэмжээг авсан. Монголбанкнаас бодлогын хүүг бууруулах, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн чанарыг муутгалгүйгээр хугацааг сунгах, ипотекийн зээлийг үргэлжлүүлэн олгох зэрэг бодлогын арга хэмжээг авсан.

Зураг 32. ДНБ-ий өсөлт, эцсийн ашиглалт


Засгийн газрын хэрэглээ 2020 онд өсөлтөд эерэг хувь нэмэр оруулжээ.

Цогц төлөвлөгөө уул уурхайн бус салбарын бизнесийн идэвхжлийг дэмжив. Бодит секторын эрсдэл, тодорхой бус байдал өндөр байсан үед 10 их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлснээр уул уурхайн бус салбаруудын үйл ажиллагаа, бизнесийн идэвхжилд эерэг дүр зураг ажиглагдаж эхэлсэн. Салбараар авч үзвэл 10 их наядын цогц төлөвлөгөөний санхүүжилтэд түлхүү хамрагдсан бөөний ба жижиглэн худалдаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын ажил эрхлэлт, үйлдвэрлэлд сэргэлт

бий болжээ. Цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон санхүүжилт нь бизнесийн эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтыг өсгөж, 2021 онд эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас голлон тэтгэсэн байна (Зураг 33).

Харин хил гаалийн хязгаарлалт, гадаад орчны таагүй нөлөөллөөс шалтгаалан уул уурхайн үйлдвэрлэл, экспорт цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргээгүй, тээвэр, агуулах, барилгын салбарууд огцом агшсан нь 2021 онд эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрэх боломжийг хязгаарлав.

Зураг 33. ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: YCS

Цар тахлын үед хэрэгжүүлсэн төсвийн багц арга хэмжээний дунд төсвийн алдагдал огцом тэлсэн бол 10 их наядын цогц төлөвлөгөөний нөлөөгөөр төсвийн орлого тэлж, алдагдал хумигддэв. Төсвийн орлого 2020 онд өмнөх оноос 14 хувиар буурсан бол төсвийн зарлага 20 хувиар өсөж, төсвийн тэнцэл 2020 онд 4.5 их наяд төгрөгийн (ДНБ-ий

12 хувь) алдагдалтай гарсан. Харин 2021 онд цар тахлын эсрэг бүх нийтийн вакцинуулалт өрнөж, вирусын тархалтын эсрэг хориг арга хэмжээнүүд суларч бизнесийн үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотойгоор төсвийн орлого 51 хувиар өсөж, төсвийн алдагдал 2.9 их наяд төгрөг (ДНБ-ий 6.8 хувь) болж буураад байна (Зураг 34).

Зураг 34. Улсын төсвийн тэнцлийн дүн болон орлого, зарлагын жилийн өсөлт




Эх сурвалж: YCX

Улсын төсвийн орлого 2020 онд өмнөх оноос 1.4 их наяд төгрөгөөр буурсан бөгөөд үүнд цар тахалтай тэмцэх багц боллогын хүрээнд орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нийт 0.92 их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлсэн нь голлон нөлөөлсөн. Харин 2021 онд татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлж,

0.5 орчим их наяд төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн хэдий ч нийтийг хамарсан хэл хорио цуцлагдаж, мөн 10 их наядын цогц төлөвлөгөөний нөлөөгөөр бизнесийн үйл ажиллагаа сэргэж, уул уурхайн түүхий эдийн үнэ өссөнөөр Улсын төсвийн орлого өмнөх оноос 51 хувиар нэмэгдэв (Шигтгээ 3).

Зураг 35. Төсвийн орлого, зарлага, нэр төрлийн ангиллаар



Эх сурвалж: YCS

Ковид-19 цар тахлын үед Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь төсөвт багагүй дарамт үүсгэж, улмаар төсвийн зардал 2020 онд 20 хувиар, 2021 онд 12 хувиар тус тус нэмэгдлээ. Хэдийгээр төсвийн дэмжлэг, арга хэмжээнүүд

нь цар тахлын хямралын үед эдийн засгийн идэвхжлийг дэмжих нөлөө үзүүлсэн ч нөгөө талдаа 2020 онд МУЗГЫН гадаад өрийн хэмжээ нэмэгджээ.

Шигтгээ 3. Ковид-19 цар тахлын үед Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн төсөвт үзүүлсэн нөлөө

Ковид-19 цар тахлын үед эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас шат дараатай олон арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь багагүй хэмжээгээр төсвийн зарлагыг тэлж, орлогыг бууруулсан. Тухайлбал:

Хүүхдийн мөнгөн тэтгэмж: 2020 оны 4-р сараас Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100,000 төгрөг болгон олгож эхэлсэн. Үүнд 2020 онд ДНБ-ий 3 хувь (1.06 их наяд төгрөг), 2021 онд ДНБ-ий 3.1%-тай тэнцэх хэмжээний мөнгө тус тус зарцуулсан.


Татварын хөнгөлөлт: Орлогын албан татвар болон Нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 оны 4-р сараас эхлэн 2021 оны 6-р сар хүртэл чөлөөлсөн. 2021 онд ДНБ-ий 1 орчим хувьтай тэнцэхүйц хэмжээний татварыг чөлөөлсөн буюу төдий хэмжээгээр татварын орлого буурсан.

Иргэн бүрт 300 мянган төгрөг: 2021 оны 5-р сарын урт хугацааны хөл хорионы үеэр иргэн бүрт 300 мянган төгрөгийн дэмжлэг олгосон. Үүнд ДНБ-ий 2.3%-тай тэнцэх хэмжээний мөнгийг улсын төсвөөс зарцуулжээ.

Вакцинд хамрагдсаны урамшуулалт: Вакцины хоёр тунгаа хийлгэсэн иргэдэд 50,000 төгрөгийн урамшуулалт олгосон. Үүнд ДНБ-ий 0.2%-тай тэнцэх хэмжээний мөнгө зарцуулсан.

Орон сууцны төлбөрийг тэглэж, шахмал түлшинд татаас олгосон: Үүнд нийт ДНБ-ий 3.8%-тай тэнцэх хэмжээний мөнгө зарцуулагдсан. Гэхдээ үүнийг төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр шийдвэрлэсэн юм.


Төрөөс үзүүлсэн хөнгөлөлт, арга хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: Mongolia economic update, World Bank, 2022

Эдийн засагт 2021 оны сэргэлт гарсан ч импорт хурдтай тэлж, урсгал тэнцлийн алдагдал нэмэгдлээ. Цар тахлын эхэн үед дотоод эрэлт буурч, хөрөнгө оруулалтууд хойшлон, газрын тосны үнэ унаж, импорт 2020 онд 0.7 тэрбум ам.доллараар буюу жилийн 12.2 хувиар агшсан. Харин цар тахлаас сэргийлэх хөл хорио цуцлагдаж, 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжин эдийн засаг, бизнесийн идэвхжил сэргэсэнтэй давхцаж импорт 2021 онд жилийн 29.4 хувиар тэлжээ (Зураг 36). 2021 оны дунд үеэс бий болсон тээвэр логистикийн хүндрэл, хилийн хязгаарлалт нь импортын өсөлтийг тодорхой хэмжээнд хязгаарласан бөгөөд хэрэв ямар нэг хориггүй байсан бол импорт илүү ихээр тэлэх байв. Бүрэлдэхүүн хэсгүүдээр авч үзэхэд импортын бүх бүрэлдэхүүн хэсгүүд тэлсэн,


Зураг 36. Импорт, бүрэлдэхүүн хэсгээр



Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

ялангуяа хэрэглээний болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт хурдтай өссөн дүр зурагтай байна. Цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон санхүүжилтийн хувьд импортын эрэлтэд үзүүлсэн нөлөөг тооцож үзвэл (цогц хөтөлбөрийн импортын орц дунджаар 44 хувь, нийт 4.2 тэрбум их наяд төгрөгийн санхүүжилт) 570 сая ам.долларын импортын эрэлтийг бий болгожээ¹. Экспортын өсөлт харьцангуй бага үед импорт өсч, гадаад худалдааны ашиг буурсан нь урсгал тэнцлийн алдагдал 2020 онд ДНБ-ий 5.1 хувиас 2021 онд ДНБ-ий 14.0 хувид хүрч тэлэхэд голлон нөлөөллөө (Зураг 37).

Зураг 37. Урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

¹ Импортын нөлөөг "Салбар хоорондын тэнцэл"-ээс эдийн засгийн салбаруудын хувьд импортын орцын шууд ба шууд бус үржүүлэгчийг авч, хөтөлбөрийн хүрээнд салбаруудаар олгосон санхүүжилтийн хувьд жигнэж тооцов.

Ашигласан эх сурвалж

International Monetary Fund. (2021). *2021 Article IV Consultation Staff Report Mongolia, Country Report No. 2021/251.* Washington DC.

International Monetary Fund. (2021). *Global Financial Stability Report: Covid-19, Crypto, and Climate: Navigating Challenging Transitions.* Washington DC.

Joffre, V. M., & Luvsandorj, B. (2020 оны December). Sustainable Recovery Options for Mongolia's Micro, Small, and Medium-Sized Enterprises. *ADB Briefs*, 160.

Legalinfo.mn. (2022). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

World Bank. (2021). *Mongolia Economic Update : From Relief to Recovery.* Ulaanbaatar: World Bank Group.

World Bank. (2022). *Mongolia Economic Update: Navigating Stronger Headwinds.* Ulaanbaatar: World Bank Group.

Монголбанк. (2021). *Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал.*

Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн Танхим. (2021). "Бизнесээ сэргээхэд тулгарч буй бэрхшээл, дэмжлэг"-Тодруулах судалгаа.

Ц.Бямбацогт, Б.Ананд, С.Билгүүнзул, & Б.Төгөлдөр. (2021). Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй бодлогын өрх, аж ахуй нэгжид үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.





МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

2021



